

ОРЧИН ҮЕ—ЖУУЛЧЛАЛ

Д. Энхтайван

Аялал жуулчлал нь дэлхийн II дайны дараагаар хөгжсөн шинэ салбарын нэг бөгөөд 50-иад жилийн хооронд дэлхийн эдийн засагт онцгой байр суурийг эзлэх болж аж ахуй санхүүгийн хямралтай үед ч тогтвортой хөгжин хэтийн ирээдүйтэй болохоо хэдийнээ нотолжээ.

Улс орнуудын хөгжлийн төвшин харилцан адилгүй байдаг ч гэсэн жуулчлалыг эрхэлснээр тэрхүү улсуудын эдийн засгийн материаллаг бааз суурь өсөн нэмэгдэх нэгэн шижим болж чаддаг байна. Жуулчлалын хамгийн онцлог чанар нь үндэсний материаллаг болон байгалийн үнэт баялгийг экспортлохгүйгээр шууд чөлөөт валют олдогт оршино.

Аялал жуулчлал Франц, Их Британи, Австри, Канад, Испани зэрэг орны тэргүүлэх салбар болж, Испанид экспортын нийт орлогын 60 хувь, Австрид 45 хувийг эзэлж, Их Британид автомашин, онгоц, архи, дарс, тамхины экспортын нийт орлоготой тэнцэх валютыг жил тутам оруулдаг байна.¹ Мексикт уг салбарын орлого экспортын нийт орлогын 50 хувь, Энэтхэг 16 хувийг эзэлж, Бразилд чөлөөт валютын эх үүсвэрийн хувьд кофены, Мексикт нефтийн дараа 2-р байранд ордог.² Турк улс олон улсын аялал жуулчлалын салбараас 1989 онд 1,8 тэрбум ам доллар олж байсан бол 1992 оноос жил тутам 5 тэрбумд хүрэх зорилт тавьж, улмаар гадаад өрөө түүгээр дарах бодлого баримталж байна.³

Карибын тэнгисийн арлын орны нэг Бахама нь жуулчлалыг хөгжүүлснээр 1990 онд улсын нийт бүтээгдэхүүний үнийн 77 хувь, улсын нийт орлогын 66 хувьтай тэнцэх ашиг орлого олжээ. Испани улс жуулчлалаас жил бүр 50 миллиард ам, долларын ашиг олдог бөгөөд энэ нь тус улсын экспортын нийт бүтээгдэхүүний 60 хувьтай тэнцдэг. Иймээс Испани орныг авран тэтгэгч нь аялал жуулчлал хэмээн хошигнодог нь учир утгагүй зүйл биш юм.

Манай өмнөд хөрш БНХАУ жуулчлалын асуудалд онцгой анхаарал хандуулж байна. Сүүлийн 10-аад жилийн дотор зөвхөн Бээжин хотод л гэхэд олон улсын чанарын түвшинд хүрэх 116 зочид буудал барьж америк, европ тивийн гол орон руу олон улсын нислэгийн шинэ шугам нээж жуулчдыг шууд хүлээж авч байна.⁵

Үүнээс гадна орчин үеийн шинжлэх ухаан техникийн хөгжлөөс нэлээд хойрогдсон, буурай эдийн засагтай, төвөөс алсад орших нутаг

Д. Энхтайван —Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан.

оронд ч аялал жуулчлалыг эрхэлж валют олж байна. Үүний нэг тодорхой жишээ бол Төвдийн өөртөө засах орон юм.

Төвдийн ард түмний соёл иргэншлийн өвөрмөц сонин чанар, хачин жигтэй байдал нь эрт дээр үеэс судлаачид, аялалчид, улс төр шашны зүтгэлтнүүдийн анхаарлыг татаж байсан хэдүйч газар зүйн саад бэрхшээл өөрийн өвөрмөц улс төрийн байгууламжийн системээрээ бүх дэлхийгээс тусгаарлагдаж энэ битүүлэг ойртоход бэрх байдал нь энэ нутаг орныг танин мэдэх эрмэлзлэлийг бадраасаар ирсэн юм. Одоогоос 300 жилийн өмнө Италийн католик шашныг номлогчид Төвдөд нэвтрэн орж чадсаныг эс тооцвол тус орны хаалга саяхныг хүртэл бараг бүх газрынханд хаалттай байлаа. Зөвхөн 70-аад оны сүүлээр л Төвдийн хэд хэдэн хотод гадны жуулчдыг хүлээн авах болсон. Жуулчлалын салбараас олсон орлого ТӨЗО-ы эдийн засагт ихээхэн үр дүнгээ өгч байна. Жишээ нь; 1985 онд 6,4 сая юань, 1987 онд энэ нь 4,5 дахин нэмэгдэж 29 сая юаний цэвэр орлого олж 2000 он гэхэд 600 сая юаньд хүргэх зорилт тавьжээ. Энэ нь 1951—52 оны үеийн нийт улсын газар тариалан, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний өртөгтэй тэнцэж буй ажээ.⁶ Жуулчдаас олох орлогын их бага байх нь хүлээн авах жуулчдын тоо хэмжээ, тэдний төлж буй хөлснөөс шалтгаалж байна.

Замын зардал, хоол унд, байр сууцны өртөг, амь даатгалтай нийлээд 1500—2000 юань төлж Төвдөд очдог. ТӨЗО-нд өнөөгийн байдлаар 20-нод зочид буудал, зоогийн газар, жуулчдад зориулсан отог 400 гаруйг шинээр нээжээ.⁷ Жуулчлалын салбарт 2500-аад ажилтан ажиллаж байна. ТӨЗО-ы Засгийн газраас малчин, тариачин хэн боловч хувиараа жуулчлалын ажил эрхэлж болохыг албан ёсоор зөвшөөрч тэдэнд хөнгөлөлтэй зээллэг олгох зэрэг дэмжлэг үзүүлж байна.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь ТӨЗО-ы эдийн засагт тодорхой байр суурийг эзэлж байгаа төдийгүй «дэлхийн дэвтэрт» орчин үеийн шинжлэх ухаан, техник соёл, боловсрол нэвтрэх, улс төрийн байр суурна бэхжүүлэхэд түлхэц болох нь зайлшгүй юм.

Орчин үед жуулчлалаас олох валютын орлого дэлхий нийтийн бараа таваарын экспортын орлогоос илүү хурдан өсөж, хөрөнгө оруулалтыг богино хугацаанд чөлөөт валютаар нөхөхийн зэрэгцээ олон улсын худалдааны элдэв хориг арга хэмжээнд автдаггүй. 1990 оны байдлаар олон улсын жуулчлал нь дэлхийн нийт бүтээгдэхүүний 14 хувьтай тэнцэх үйлдвэрлэл, үйлчилгээ явуулжээ. Тус салбарын орлого өнөөдөр дэлхийн нийт экспортын 9 хувьтай тэнцэх бөгөөд 2000 он хүртэл жилд дунджаар 4 хувь өсөх хандлагатай байна.⁸

Манай орны хувьд дотоодын аялал жуулчлал танин мэдэхүйн хэрэгсэл, орлогын эх үүсвэр болтлоо хөгжиж хараахан чадаагүй байна. Харин олон улсын аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх бололцоо бүрэн байгаа төдийгүй материаллаг болон байгалийн баялгийг экспортлохгүй шууд чөлөөт валют олдог цорын ганц салбар учир онцгой анхаарч, бодлого болгон хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Манай эдийн засгийн гадаад харилцааны салбарт олон улсын аялал жуулчлал яльгүй бага байр суурийг эзэлдэг боловч бусад салбарыг бодвол нэг америк долларыг хамгийн бага зардлаар олдог байна. Үйлчилгээний зэргээс шалтгаалан нэг жуулчнаас олж буй чөлөөт валютаар өрнөдийн зах зээл дээр өнгөт телевизэр 2, эсвэл 3 тонн нефть худалдан авах боломжтой юм.⁹ Судалгаанаас үзэхэд «Жуулчин» нэгтгэл нэг ам. доллар олоход 2,91 (хуучин ханшаар) төгрөг зарцуулж байгаа нь манай улсын барааны экспортынхоос даруй 2 дахин бага байгаа юм.¹⁰

Аялал жуулчлалыг цаашид хөгжүүлэх нь эдийн засгийн нээлттэй бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд манай улс ардын аж ахуйн бусад салбарыг хөгжүүлэх үйл явцтай нягт холбоотой. Эдийн засгийн нээлттэй бодлогыг хэрэгжүүлэх явцад экспортын чиглэлтэй жижиг, дунд үйлдвэрийг дэвшилт технологиор хамтрах буюу дангаараа байгуулах, үйлдвэрийн дэд бүтцийг богино хугацаанд бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай ажээ. Эдгээр чиглэлийг баримталж эдийн засгийн нээлттэй бодлогыг хэрэгжүүлэхэд олон улсын аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх явдал чухал боллоо. Энэ нь нэг талаас эдийн засгийн бусад салбарт валютаар оруулах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг богино хугацаанд нэмэгдүүлэх, шинэ техник, технологи худалдан авах, боловсон хүчин бэлтгэх боломжийг бий болгохын зэрэгцээ зам тээвэр, холбоо, ахуйн үйлчилгээг дэлхийн түвшинд хүргэхэд нөлөөлөх нь мэдээж юм.

Эцэст нь тэмдэглэхэд зах зээлийн нөхцөлд аялал жуулчлалын салбарыг бие даалган хөгжүүлснээр уналтын байдалд байгаа манай ядуу эдийн засгийн хөгжилтөнд нааштай нөлөөлөх хүчин зүйлийн нэг мөнөөс мөн гэдэг нь маргаангүй юм.

1991 онд Улаанбаатар хотноо Зүүн хойт Азийн орнуудын тээвэр, холбоо, жуулчлалын асуудлаар болсон эрдэмтэд экспертүүдийн уулзалтаар Монголд аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломж байгааг судалгааны үндэслэлтэй онцлон тэмдэглэж байсан юм. Иймээс хоёр талын болон олон улсын уулзалт ярилцлагыг үр ашигтай хэлбэрээр зохион байгуулах явдал чухал шаардлагатай байна.

Дэлхийн банк, Олон улсын валютын сан болон бусад тусламж дэмжлэгийн хөрөнгө мөнгөний тодорхой нэг хэсгийг улс орныхоо аялал жуулчлалын үйлсийг өргөтгөн хөгжүүлэхэд зориулах нь зүйтэй юм. Үүний зэрэгцээ хөрөнгө хүч төдийлөн шаардахгүй дотооддоо зохион байгуулж санаачлан хийх ажил ч их байна. Тухайлбал: монгол гэрийг аялагчдын орон сууц болгож, дээд зэргийн боловсруулалттай цагаан идээг хоол хүнсэнд нь өргөн хэрэглэж сурталчлах, бэлчээрийн мал аж ахуй, байгаль, нүүдэлчин монголчуудын ахуй амьдралын онцлог шинжийг сонирхуулах, түүх соёлын дурсгалт газар орон, сүм хийдийг гол үзмэр болон үндэсний гар урлалын салбарыг хөгжүүлэх нь зах зээлийн худалдааны эргэлтэнд ашигтай нөлөөлөх нь маргаангүй.

1. «Үндэсний эдийн засаг», 1991, № 3, 10-р тал
2. Мөн тэнд.
3. Мөн тэнд.
4. «Tibetan studies», 1990. № 1., 18-р тал.
5. «China's Tibet», 1991, № 2, 9-р тал.
6. Ren min ribao (Ардын өдрийн сонин). 1989, IX. 17.
7. «China a trade surbibal kit», 1990. 19-р тал
8. «Үндэсний эдийн засаг», 1991, № 3, 11-р тал.
9. Мөн тэнд.
10. Мөн тэнд.